

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫН ЗОРИЛГО, ЗАРЧИМ-ЗАН ҮЙЛТЭЙ ХОЛБОГДОХ НЬ

Ч.Пүрэвээ¹, Ц.Ариунзаяа¹
Purevee@mnms.edu.mn

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор М.Оюун

Үндэслэл

Энэхүү судалгааны ажил нь нийгмийн эрүүл мэндийн боловсролоор дамжуулан халдварт бус өвчлөлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх замаар хүний амьдралын чанарыг сайжруулах судалгаанд чиглэгдсэн болно. Өнөөдөр даяаршил, шинжлэх ухаан, технологийн дэвшлийн эрин үе нь нээлттэй, өрсөлдөөнтэй, мэдээлэлжсэн орчинд амьдрах чадварыг хүн бүрээс шаардаж байгаагаас дэлхийн улс орнууд хүн төвтэй тогтвортой хөгжлийн бодлогыг мэдлэг чадвартай, бүтээлч, хариуцлагатай, насан туршдаа суралцах чадвартай иргэн төлөвшүүлэхэд чиглүүлж, боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн асуудлыг цогцоор нь авч үзэн тэдний эрэлт хэрэгцээг хангахуйц түвшинд шинэчлэн зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Иймээс зөвхөн мэдлэг олгохоос гадна зөв зан үйл төлөвшүүлэх, хандлагыг өөрчлөн улмаар аливаа тохиолдож болох эрсдэлээс урьдчилан сэргийлж боловсрол олгох нь чухал юм. Соёл иргэншил, амьдралын хэв маяг, хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ, гаж буруу дадал, зан үйлээс шалтгаалах өвчний тархалт асар хурдацтай болж хүний амьдрал, эрүүл мэндэд эрсдэл учруулан улмаар нийгэм, эдийн засгийн хөгжилд ч нөлөөлж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн боловсролын тулгамдсан асуудлын нэг юм.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь нийгмийн эрүүл мэндийн боловсрол болон зан үйлийн онолыг таниулахад чиглэсэн болно.

Судалгааны ажлын зорилт

- Орчин үеийн боловсрол судлал, нийгмийн эрүүл мэндийн боловсролын талаарх эрдэм шинжилгээ судалгааны бүтээлүүдийг уншиж судлах, судлаачдын үзэл баримтлалыг нэгтгэн дүгнэх.
- Зан үйлийн онол, түүний төрөл хэлбэрүүд, нийгмийн эрүүл мэндийн боловсролын уялдаа, ач холбогдлыг тодорхойлох.

Судалгааны ажлын материал

Энэхүү судалгааны ажилд

- Эрдэмтдийн нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн боловсрол, онолын болон практик ажлын бүтээлүүдээс;
- Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль (2002), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008), ЮНЕСКО-гийн боловсролын бодлого, “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал” (УИХ, 1996), “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” (УИХ, 2008). “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2007-2021), Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, “Монгол улсын төрөөс гэр бүлийн талаар баримтлах бодлого” (2003), “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (1995, 2015), Мянганы хөгжлийн зорилтууд (MDG), “Тогтвортой хөгжлийн зорилтууд” (SDG);
- “Даян дэлхийн тогтвортой хөгжлийн XXI зууны хөтөлбөр”(1992), “Тогтвортой хөгжлийн боловсролын 10 жил” (2002), “Монгол Улсын боловсролын салбарыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”, “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021), Нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөр.(2008), “Бүх нийтийн боловсролын орчны нэгдсэн үнэлгээ” (2005, БСШУЯ), “Монгол Улс дахь Тогтвортой хөгжлийн боловсролын олон түвшинт суурь судалгаа” (2014, БШУЯ)
- Эрүүл нийгэм, бүх нийтийн эрүүл мэндийг сайжруулах Аделейдагийн тунхаг (Declaration Adeleida.1997), Лалондын тунхаг (Declaration Lalonda.1974), Эрүүл мэндийн шинэ хэтийн төлөв 1977, Алма Атагийн тунхаг (Declaration Alma-Ata.1978), ДЭМБ- бүх нийтийн эрүүд мэнд 2000), Жакартын тунхаг (Declaration Jakarta. 1997), Оттавагийн тунхаг (Declaration Ottawa. 1986), “Тогтвортой хөгжлийн тунхаг” (Declaration on Sustainable Development 1972), “Рио+20” (2012), “ТХБ-ын 10 жил 2005-2014”-ийг дэлхий дахинд тунхагууд, олон улсын болон өөрийн орны эрх зүйн баримт, бодлого, хөтөлбөр, тогтоол:

Судалгааны ажлын арга

Судалгааны ажилдаа бид тоон болон чанарын аргаар баримт материал цуглуулах, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, системчлэх зэрэг аргуудыг түлхүү ашигласан.

Судалгааны ажлын үр дүн

Нийгмийн эрүүл мэндийн талаар дэлхий нийтэд баримталж буй бодлого, үйл ажиллагаа нь дан гац өвчнийг эмчлэх биш хүн амд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, амьдарч сурч, ажиллаж буй орчиндоо эрүүл мэндэд таатай нөхцөл, нөлөөллийг бүрдүүлэхэд нь хүмүүст туслах, түүнд харилцан бие биесээ дэмждэг олон салбарын болон нийгмийн дэд бүтцийн хамтын ажиллагаа чиглүүлэх, боловсролыг бүхий л талаар олгох замаар хүн амын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэхэд чиглэгдэж байна. ДЭМБ-с нийгмийн эрүүл мэндийн боловсролыг олгохын тулд хамгийн чухал анхаарах зүйл бол бүх анги давхарга, улс гүрэн, хүн ардын дунд тусгайлсан судалгаа шинжилгээ явуулж түүн дээр үндэслэсэн бодлого, хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулсны үндсэн дээр эрүүл мэндийн бүх чиглэлийн үйлчилгээ (боловсрол олгох, тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэлт, эдийн засаг, гэх мэт) явуулах ёстойг чухалчилсан байдаг. НЭМБ-ийг хүн амд боловсрол олгосноор асуудлын жинхэнэ шалтгааныг арилгах ба хүний буруу зан үйлийг тогтвортой өөрчилж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэн өвчнөөс урьдчилан сэргийлэх боломж олгох бөгөөд урьдчилан сэргийлэх нь өвчлөөд эм хэрэглэхээс илүү хялбар, өртөг зардал бага шаарддаг ач холбогдолтой юм. Нийгмийн эрүүл мэндийн боловсролын зорилгыг:

- Хүмүүсийн эрүүл мэндэд нь нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх;
- Эрүүл зан үйлийг дэмжих;
- Эрүүл мэндийг дэмжих орчин, эрүүл амьдралын хэв маягийг бүрдүүлж амьдрахад хүмүүсийг идэвхжүүлэх;
- Эрүүл мэндийн тохирсон үйлчилгээ ялангуяа өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээг хэрэглэхийг дэмжих;
- Эрүүл мэндийн шинэ мэдлэгээр хангах, хүмүүсийн чадварыг хөгжүүлэх;
- Өөрийн эрүүл мэндийн асуудлуудыг шийдвэрлэх хандлагатай олон нийтэд эмнэлгийн үйлчилгээний давуу тал, тэдгээрийн хэрэглээ болон үйлчилгээний хязгаарлагдмал байдлыг мэдээлэх;
- Хувь хүн ба олон нийтийг өөрсдийн эрүүл мэндийн асуудлаа тодорхойлохоос эхлээд шийдвэрлэх хүртэл бүх үе шатанд оролцох байдлаар эрүүл мэндийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг дэмжих явдал юм гэж тодорхойлж болох юм.

Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих цогц үйл ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн эрүүл мэндийн боловсрол бөгөөд үүнийг хүснэгтээр илэрхийлвэл:

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ	
Хүмүүст эрүүл мэндээ хэрхэн дэмжих, хадгалах, засах арга барил сургах үйл ажиллагааг системтэйгээр олгох ЦОГЦ үйл ажиллагаа.	
Орчны эрүүл мэндийн боловсрол	Бие бялдрын эрүүл мэндийн боловсрол
Нийгмийн эрүүл мэндийн боловсрол	Сэтгэл санаа, оюун санааны эрүүл мэндийн боловсрол

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ

Нийгмийн эрүүл мэндийн боловсролын үндсэн зарчим нь судалгааны хамгийн сүүлийн үеийн мэдлэгээр хангагдсан, системтэй, ойлгомжтой, үйл ажиллагаа нь тогтвортой байх, хувь хүний нас, хүйс, боловсрол, эрүүл мэнд, сэтгэц болон нийгмийн байдалд тохирсон байх, хувь хүний оролцоог дэмжсэн байдаг.

НЭМБ-ын нэг хэсэг нь өвчний эрсдэлт хүчин зүйлс бөгөөд эрүүл амьдралын хэв маягийн талаар боловсрол олгох замаар эрүүл зан үйлийн асуудалд анхаарлаа хандуулж, хүн ам, тодорхой бүлэг, хувь хүмүүст чиглэдэг. Ингэхдээ мэдлэг олгох, эрүүл мэндийг дэмжих чадавхыг хөгжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг. Амьдралын зөв дадал зуршил, хэв маягийн талаарх мэдлэг олгох ажилд эрүүл мэндийн мэргэжилтнүүд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд дараах үзэл баримтлал тунхаг бичигт зааснаар:

1. Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох + дэмжих орчин бүрдүүлэх = эрүүл мэндийг дэмжих (Tones and Tilford, 1994)

2. Эрүүл мэндийг дэмжих нь хүн амыг хамгаалах хамгийн үр дүнтэй, хямд төсөр арга төдийгүй улс орны тогтвортой хөгжлийн цөм асуудал болохыг засгийн газрууд хүлээн зөвшөөрч эрүүл мэндийг дэмжих шинэ тунхаглал зэрэг (Дэлхийн чуулган, Бангкок, 2005) нийгмийн эрүүл мэндийн боловсрол, хууль тогтоомж, хувь хүн хамт олны хөгжил, оролцооны үр дүнтэй механизмуудыг хослон хэрэглэхийг баталгаажуулсан байна^{10,11}. Дээрх онол болон тунхаг бичгүүдээс үзэхэд нийгмийн эрүүл мэндийн боловсрол нь дан ганц эрүүл мэндийн салбарын үйлчилгээ биш боловсролын салбарын, нийгэм улс, төрийн хүрээний асуудал биш болох нь харагдаж байгаа төдийгүй дараах баримт бичгүүдэд тодорхойлсноос үзэхэд нийгмийн хамгийн чухал тэргүүлэх чиглэлийн бодлогод тусгагдсан байна.

Хүснэгт 1. Зан үйлийн жишээ (эрүүл, эрсдэлтэй)

- Тогтмол цагт зөв хооллодог - Өөрт тохирсон идэвхтэй хөдөлгөөн хийх - Урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдах - Хүүхдээ вакцинжуулалтад хамруулах - Цэвэр аюулгүй орчин бүрдүүлэх - Чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх	- Архи, тамхи хэрэглэх - Тохиолдлын бэлгийн хавьталд хамгаалалтгүй орох - Эмийг дур мэдэн хэрэглэх - Буруу хооллох - Тоглоомд донтох
Эрүүл зан үйл	Эрсдэлтэй зан үйл

Зан үйлд нөлөөлөх, түүнийг өөрчлөх оролдлого нь урт хугацааны туршид эрүүл мэндийг хамгаалах чухал асуудлын нэг хэсэг болж ирсэн бөгөөд хүмүүсийн амьдралын хэвшлийг орчин цагийн олон өвчний шалтгаан гэж үздэг. Үүнд:

- Юуг? Ямар зан үйл, үйлдэл, дадал зуршлыг эзэмшүүлэхийг зорьж байгаа
- Яагаад? Тухайн зан үйл эзэмшихэд нөлөөлдөг шалтгаан хүчин зүйлс
- Хэзээ? Үйл ажиллагааг зөв цагт, зөв дарааллаар хэрэгжүүлэх
- Яаж? Зан үйлийн өөрчлөлтийг ямар арга замаар бий болгох

Хүний зан үйлийг өөрчлөх оролдлого нь нийгмийн эрүүл мэндийн боловсрол, зөвлөгөө өгөх, замаар аливаа хүчин зүйлүүдийг хамруулах, мөн хүний хувийн шинж болон эрүүл мэндийн асуудлуудтай нь хэр уялдаж байгаа зэрэгт чиглэх хэрэгтэй байдаг байна. Эрүүл мэндэд нөлөөтэй зан үйлийг дараах хэд хэдэн онолоор тайлбарладаг байна²⁴.

- Юуг? Ямар зан үйл, үйлдэл, дадал зуршлыг эзэмшүүлэхийг зорьж байгаа;
- Яагаад? Тухайн зан үйл эзэмшихэд нөлөөлдөг шалтгаан хүчин зүйлс;
- Хэзээ? Үйл ажиллагааг зөв цагт, зөв дарааллаар хэрэгжүүлэх;
- Яаж? Зан үйлийн өөрчлөлтийг ямар арга замаар бий болгох;

Эдгээр онолуудын ихэнх нь зан үйлд чиглэсэн өөртөө итгэлтэй байдал, сэтгэл хөдлөл, өөрийн стандарт, зан үйлийн хэм хэмжээ, хүлээгдсэн үр дүн, ур чадвар, зан үйлд саад болдог гаднын шахалтууд, зан үйлийн завдалт зэрэг олон хүчин зүйлүүдийг хамруулан тайлбарладаг байна өөрөөр хэлбэл хувь хүн нь (1); зан үйлийг үйлдэхэд нь түлхэх тууштай эерэг завдалт, хүсэл сонирхолтой байх ёстой, (2); зан үйлийг төлөвшихөд нь нийгмийн орчны, бие махбодын болоод аргачлалын хувьд байж болох саад бэрхшээлийн талаарх үндсэн мэдээллийг авсан байх; (3) тухайн зан үйлд төлөвшихийн тулд өөрт чухал ур чадварууд байгаа гэдгийг ухамсарлах ёстой; (4) зан үйлийг материаллаг болон нийгмийн буюу бусад урамшуулал баталгаа дагана гэдэгт итгэх; (5) зан үйлийн хариуд сайшаал, урамшууллыг хүртэхгүйгээс гадна янз бүрийн

дарамт, ачаалал гарч ирдэг талаар мэддэг байх; (6) хувь хүний өөрийн тусгалтай хамт зан үйл нь тогтмол шинжтэй талаар мэддэг байх; (7) зан үйл нь эерэг нөлөөллүүдтэй гэдгийг мэддэг; (8) зан үйлийн хэзээ хаана үйлдэхийг мэддэг, ойлгодог байх, боломжтой нөхцөлийг олж хардаг байна.

Эрүүл мэндэд нөлөөтэй зан үйлийг дараах хэд хэдэн онолоор тайлбарладаг байна²⁴. Үүнд:

1. Хувь хүний зан үйлийг тайлбарладаг онолууд;
2. Хүн хоорондын зан үйлийг тайлбарладаг зарим онолууд
3. Олон нийт болон нийгмийн зан үйлийг тайлбарладаг зарим онолууд

Эдгээр онолуудын аль нь ч бүх зан үйлийг дангаараа тайлбарлах боломжгүй бөгөөд зан үйлийг өөр өөр талаас нь тайлбарласан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн итгэл үнэмшлийн загвар. (Беккер, Гочбаум, 1974)
- Шалтгаант үйлдлийн онол. (Фишбеин, Азжен. 1975)
- Өөрчлөлтийн үе шатны онол. (Прочаска, Диклиемэнт 1984)
- Нийгмийн танин мэдэхүйн онол. (Альберт Бандура. 1986)
- Нийгмийн сүлжээ ба нийгмийн дэмжлэгийн онол. (Израил. 1985, 1990)
- Шинэ мэдлэг, ойлголт тархах онол (Эверетт Рожерс.1962)

Дээрх онолууд нь бүгд нийгмийн эрүүл мэндийн боловсролыг олгох, түгээх, хэрэгжүүлэх үйлд харилцан уялдаа хамааралтай байж хувь хүн, хамт олон, олон нийтэд мэдэг олгох мэдээлэл хүргэх, зан үйлийг өөрчлөх боломжийг бүрдүүлдэг нь харагдаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг олон улсын эрүүл мэндийн байгууллагууд дараах загвараар тодорхойлжээ.



Схем 1. Эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих үйл ажиллагаа

Дээрх схемээс харахад нийгмийн эрүүл мэндийн боловсрол, зөвлөгөө, эрүүл мэндийг дэмжих, сайжруулах улмаар халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, бууруулахад хамгийн үр дүнтэй арга болох нь харагдаж байна.

Халдварт бус өвчнөөс сэргийлэх, гэмтэхээс болгоомжлох, өвчлөхөөс сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд онцгой анхаарах үүднээс дараах НЭМБ-ын заалтуудыг онцгойлон оруулсан байдаг. Дээрх албан ёсны хөтөлбөрийг зааж хүүхдэд мэдлэг, дадал, хандлага эзэмшүүлэх нь тухайн сургалтын баг, багш нар, эцэг эхийн хамтын ажиллагаа байх ёстой болж байна.

Иймээс нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох асуудалд сургуулийн өмнөх боловсролын олгож буй багш, ажиллагчид бага насны хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр явуулж буй аливаа үйл ажиллагаандаа эцэг эх, гэр бүлийн оролцох эрхийг хангах, үүргээ ухамсарлан биелүүлэх боломжийг бүрдүүлэх талаар хамтран ажиллах шаардлагатай байна.

Иргэдэд эрүүл мэндийн боловсролыг зөвхөн сургуулиар олгож ирсэн дэлхий нийтийн чиг хандлага сүүлийн 20 гаруй жилд өөрчлөгдөж, зах зээлийн эдийн засаг бүхий орнуудад хүн амынхаа боловсролын түвшин тэдний хэрэгцээ бололцоонд нь тулгуурлан дээшлүүлэх, иргэдээ хөгжүүлэх чиглэлээр боловсролынхоо тогтолцоог өөрчилж, сургуулиас гадуур боловсрол олгох арга, хэлбэр бий болжээ. Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, өрх гэр, хүн бүр зах зээлд бие даан оролцох хүрээ нь өргөжихийн хэрээр тэдэнд эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх ёсонд суралцах, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг олон талын мэдлэгтэй байх зэрэг боловсролын шинэ хэрэгцээ шаардлага чухалчилж үзэх болсон.

Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Монгол улсын засгийн газрыг төлөөлж Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь НҮБ-ийн соёлын байгууллага, түүний Ази, Номхон далайн бүсийн товчоо (Regional Bureau for Asia and the Pacific), Хүүхдийн сан (Children's Fund), Насан туршийн боловсрол, соёлын төв (Lifelong education/learning, cultural center), Швейцарийн хөгжлийн агентлаг (Swiss Development Agency-SDC), Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (German Society for international Cooperation - GIZ), Шведийн Упсала Их Сургууль (Uppsala University in Sweden-UU), Швейцарийн Боловсролын салбар дахь ОУ-ын Хамтын Ажиллагааны Хүрээлэн (Institute for International Cooperation in Education IZB), Монголын мянганы сорилтын сан (Mongolian Millennium Challenge Corporation) гэх мэт олон улсын байгууллагууд болон мэргэжлийн бусад төрөлжсөн байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлэх, сургалт, семинар зохион байгуулж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн боловсрол нь халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрүүл аж

төрөх ёс, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон цаашлаад эрүүл нийгмийг бүрдүүлэх үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болох нь харагдаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн боловсролын талаарх үзэл баримтлал, онол мэдлэгийг дээшлүүлэх арга, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн эерэг зан үйлүүдийг эзэмшүүлж, хэвшүүлэхийн тулд өөрийн орны нөхцөл байдалд тохирсон онол, мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга замыг сонгон авч хэрэгжүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн боловсролын зорилго, зарчим зан үйлтэй салашгүй холбогдож буй нь дээрх судалгаагаар батлагдаж байгаа юм.

Дүгнэлт

- Нийгмийн эрүүл мэндийн боловсрол нь нийгэм, эрүүл мэнд, анагаах, сэтгэл зүй, боловсрол судлал зэрэг олон шинжлэх ухааны зааг дээр хөгжиж байгаа орчин үеийн боловсрол судлалын нэг чиглэл бөгөөд хүнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэхэд чиглэсэн мэдлэг олгох, чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэгдэж байна.
- Хүн нийгмийн үнэт баялаг болохын хувьд түүний эрүүл мэндийг хамгаалах үзэл баримтлал нь 1920-иод оны үеэс өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийтийг хамарсан үзлэг, оношилгоо хийхэд, чиглэгдэж байсан бол хүмүүнлэг ардчилсан байх зарчмыг эрхэмлэж буй өнөө үед хүнийг эрүүл байлгахад олон нийт, бүлэг, хувь иргэний сэтгэл зүй, зан үйл дээр анхаарах асуудал тэргүүлж байна.